



**ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Улсын хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн
иргэдийн бүртгэл, хяналтын талаар
авах зарим арга хэмжээний тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.3 дахь заалт, Хилийн боомтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2015 оны А/84 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2015 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэнийг улсын хилээр гарах эрхийг нь түдгэлзүүлэх, түдгэлзүүлэхийг хүчингүй болгохдоо эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн байгууллагын даргын тушаалаар тус улсаас гарахыг түдгэлзүүлэх, түдгэлзүүлэхийг хүчингүй болгосугай.

2. Гадаадын иргэний Монгол Улсаас гарах эрхийг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгосон шийдвэр гаргуулж, бүртгэлийн Вогех, Nicos програмд бүртгэж байхыг Хяналт, шалгалтын газар /Х.Бэхбат/-т, гадаадын иргэнийг хилээр үл нэвтрүүлэх бүртгэлд бүртгэсэн, бүртгэлээс хассан мэдээлэл боомтуудад хүрсэн эсэхэд хяналт тавих үүргийг Шалган нэвтрүүлэх газар /Г.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

3. Монгол Улсын иргэнийг эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хилээр гарах эрхийг нь түдгэлзүүлэх, түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай албан бичгийг үндэслэн хил үл нэвтрүүлэх бүртгэлд авах, бүртгэлээс хасах, хяналт тавихыг Шалган нэвтрүүлэх газар /Г.Ганбат/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2015 оны А/08 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Дэд дарга /Л.Баатарчулуун/-д, биелэлтийг хангаж ажиллахыг Хяналт, шалгалтын газар /Х.Бэхбат/-т, Шалган нэвтрүүлэх газар /Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ПҮРЭВДОРЖ

ИХШХЕГ /Тушаал 2015/

000734